

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилт

Сайнцагаан

2020.12.02

Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хариуцах эзэн
МУ-ын хууль				
Ерөнхийлөгчийн зарлиг				
1	6	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Харъяа төсөвт байгууллагууд монгол бичиг, кирилл бичгийг хослуулан байгууллагын хаяг болон анги танхимынхаа хаягийг бичиж байрлууллаа. МУЗБагш нар БСУГ-тай хамтран 24 төрийн албаны шалгалтанд бэлтгэж буй иргэдэд модуль сургалтыг 3 долоо хоног, МУЗБагш Д.Отгонсүрэн Цагдаагийн газарт 4 удаа монгол бичгийн сургалтыг 30, Шүүх 28 албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Хүмүүнлэг сургуулийн МУЗБагш Д.Отгонсүрэн, 10 шавь нарын хамт Монгол бичиг бидний ирээдүй өдөрлөгийг үндэсний бичгийг сурталчилах, туршлага судлах сургалт арга хэмжээг Хулд суманд зохион байгуулж, 50 багш, суралцагчид хамрагдлаа. Монголын сайхан бичигтэн улсын уралдаанд 2 сурагч шалгарч, Хүмүүнлэг сургуулийн сурагч Э.Энхзулын бүтээл тэргүүн байранд шалгарч МУИС-д суралцах урилга, 4 жил үнэ төлбөргүй суралцах эрхээр шагнагдлаа. Хэрэгжилт-70
ҮАБЗ-ийн зөвлөмж				
2	10	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.2. Хүн амын ундны ус хангамжийн баталгаат байдлыг хангах үүднээс хот, суурин газрын ус хангамжийн эрүүл бүсийг тогтоон, хамгаалалтад авч газар олголт хийхгүй байх, газар чөлөөлөх ажлыг орон нутгийн удирдлагууд шуурхай зохион байгуулах.	Сумын ИТХурлын 2020 оны 21 дугаар тогтоолоор Олгойн говийн гүний 3 худаг, сумын төвд гүний 3 худаг, насос станц 3, ус түгээх байр 18 , нийт 27 газрыг хамгаалалтын зурвас дотор шинээр газар олгохгүй байна. Хэрэгжилт-100
	11	2019-12-31 Дугаар 2019_60/40	2.3. Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлэх зорилгоор	“Дундговь ус” ОНӨҮГазартай хамтран гүний 6, 3 насос станц, 18 ус түгээх байрнуудад сард 1 удаа тогтмол хяналт хийж, дэглэм мөрдүүллээ.

			усны сан бүхий хамгаалалтын бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх	Хэрэгжилт -70
ЗГ-ын тогтоол				
3	17	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149	1.Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх 9 төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, “ХУР”системийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээнийн хүсэлтийн бүртгэлийн хяналтын системээр нийт 379 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Үүнд: хууль сахиулах байгууллагын тодорхойлолт-352, хаягийн тодорхойлолт-9, даатгал-7, үл хөдлөх 4, жолоодох эрх 6, гэрлэлт 1 гаргалаа. Хэрэгжилт -100
4	36		3.Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.	Энэ онд нийт 34 худалдан авах ажил, арга хэмжээг төлөвлөн хуулийн хугацаанд буюу төсөв батлагдсанаас хойш 5 хоногийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчаар батлууллаа. Төлөвлөгөөг tender.gov.mn болон шилэн дансны сайтад ил тод байрлуулан үр дүн, хэрэгжилтийг тогтмол оруулан олон нийтэд мэдээллээ. Үүнээс 22 ажил, арга хэмжээ, аймгаас эрх шилжиж ирсэн 5 ажил нийт 27 ажлын тендер зарлахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 23 тендерийг хуулийн дагуу зохион байгууллаа. Эдгээр зохион байгуулсан тендерүүдийг цахим систем буюу tender.gov.mn системээр амжилттай зарлагдаад байна. Зарлагдаагүй байгаа 4 тендер нь Монгол улсад үүссэн цар тахлын улмаас хойшлогдож, зарлагдах бэлтгэл ажил хийгдэж байна. Хэрэгжилт-100
5	44	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106	1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам,	Жилийн эцэст албан тоот, ажлын тайлан, малын тооны А данс ,холбогдох бусад баримт бичгийг архивын нэгж үүсгэлээ. Архив албан бичгийн стандартыг мөрдөж ажиллахад тогтмол анхаарлаа. Хуулийн дагуу 2008 оноос өмнөх хадгаламжийн нэгжийг төрийн архивт тушаасан байна. Харьяа боловсролын

6			Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	байгууллагын удирдлагын шийдвэрүүдийг хянаж, зөвлөмж хүргүүллээ.
	45		2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	Хэрэгжилт -100 Байгууллагын архивын өрөөг тохижуулан шинээр архивын тавиурыг суурилуулан баримтуудын байршууллаа. Удирдлагуудын иргэдэд чиглэсэн 13 тогтоол, 57 захирамжийг цахимд байршууллаа.
	82	2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22	ХҮИИ.2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг	Хэрэгжилт-70 2.1 Сумын хэмжээнд 2020 онд нийт 34 худалдан авах ажил, арга хэмжээг төлөвлөн хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчаар батлууллаа. Үүнээс 22 ажил, арга хэмжээ, аймгаас эрх шилжиж ирсэн 5 ажил нийт 27 ажлын тендер зарлахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 23 тендерийг хуулийн дагуу зохион байгуулж цахим систем буюу tender.gov.mn системээр амжилттай зарлалаа 2.2 Худалдан авах ажиллагаа буюу зарласан тендер бүрийн үр дүнг цахим системд нийтэлж иргэд үзэж танилцах боломжийг олголоо. Shilendans.mn системд тогтмол мэдээллээ. Аймгийн Орон нутгийн өмчийн газарт мэдээ тайланг тогтмол хүргүүллээ. 2.3 Зарлагдсан тендерүүдийг тендер хүчинтэй байх хугацаанд шалгарсан 23 гүйцэтгэгчтэй гэрээг байгуулан үр дүнг тооцож комисс томилон хүлээн авах ажлыг явууллаа. 2.4 Тендерийн баримт бичгийг сумын Засаг дарга, байгууллагын даргаар хянуулан батлуулж, зарлан тендерийн баримт бичигтэй холбоотой ямар нэгэн гомдол гараагүй байна.

			боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах.	Хэрэгжилт-100
7	85	2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дүгээр тэмдэглэл 2020-04-29 Дугаар 2020_28	IX.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах.	Тус ЗДТГазар нь 11 сарын байдлаар давхардсан тоогоор 19 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл-15.452.680төгрөг, тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж багийн засаг дарга Л.Батбаярт - 6.827.500 төгрөг, мөнгөн урамшууллыг 6 албан хаагчдад- 6.851.497 төгрөг тус тус олголоо.
8	86	2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл 2020-05-13 Дугаар 2020_31	ХҮ.4. Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд МААхуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Энэ онд малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах, ангилах, тээвэрлэх, нэхий элдэх зориулалтаар 3 иргэн, 1 ААНэгж, нийт 4 төсөлд 102 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг СХС-аас олгож, 400 гаруй хонины нэхий элдэж, 16 тн дайварыг ангилж тээвэрлэлээ.
ЗГ-ын албан даалгавар				

9	95	Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай 2020-02-10 Дугаар 2020_01	1. Хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх, “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг болон “Журам, чиглэл батлах тухай” Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас дараах албан даалгаврыг өгч байна: Нэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт: 1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж гарган харьяалах нутаг дэвсгэртээ хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;	Сумын Засаг даргын А/78 тоот захирамжийн хүрээнд малын сэг зэмийн устгал ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хөдөөгийн 4 багт 4-н ажлын хэсэг гарган зохион байгуулж хяналт тавилаа. Хөдөөгийн 4 багт болон аймгийн төв орчим, засмал зам дагуу 569 км явж, үхсэн малын нийт 821 сэг зэмийг цуглуулж, аймгийн төвлөрсөн хогийн цэгт булж ариутгал халдваргүйтгэлийг хийлээ. Мөн 32 өвөлжөө, 18 уст цэг, бэлчээрийн 11900 мкв талбайг ариутгалаа. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт /Довын хөндий / оторлож явсан Тэвш багийн 3 өрхийн мал үерт өртөж, устгалыг 5*5 км талбайн 2100 орчим сэг зэмийг цуглуулж, 2 хоногийн хугацаанд бүрэн устгал хийлээ.
	96		1.2. Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, мөн олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэн энэ ажлын зорилго ач холбогдлыг өргөн сурталчлах;	Сэг зэмийн устгалд 4 машинтай 16 малчинг дайчлан ажиллуулж 158620 төгрөгийн шатахуун зарцууллаа. Тэвш багийн 3 өрхийн мал үерт өртөж, устгалыг 23 төрийн албан хаагч, цэргийн дүйцүүлэх албан хаагч 9 иргэн, авто машин 7 ажиллаж, 3.2 сая төгрөг зарцууллаа.

Хэрэгжилт-100

Хэрэгжилт-100

ХЭРЭГЖИЛТ- 92.5%

ХЯНАСАН:

ТГ-ЫН ДАРГА

Б.ОЮУНЧИМЭГ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Э.ЦЭРЭННАДМИД